



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/440

Номгон


Бог малын хээлтүүлэгчийг ялган тэмдэглэхэд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" дахь заалт, "Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг үнэ батлах тухай" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/68 дугаар тушаал, "Мал бүртгэлжүүлэлтийн аян зохион байгуулах тухай" Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/72 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны 61-р тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Мал бүртгэлжүүлэх аян зохион байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2021 оны А/275 дугаар захирамжаар батлагдсан "Мал бүртгэлжүүлэх аян"-ыг хэрэгжүүлэх зорилгоор нийт 6196 толгой бог малын хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж, үзлэг ангилалт хийх ажлыг чанартай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Баттөр)-т үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах 9,294,000 (есөн сая хоёр зуун ерэн дөрөв мянга) - н төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Хишигбаатар)- т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210021